

АУДИТ

БУМ, МУМНБ, АЭ Б.Болортуул

Аудитын тухай ойлголт /2017.02.06/

Аудит гэж юу вэ?

Ямар нэгэн үйл явдлын итгэх зэргийг нэмэгдүүлэх зорилгоор итгэх зэрэг өндөр баталгаажуулах үйлчилгээгээр хангах мэргэжлийн үйлчилгээг хэлнэ.

Энэ ойлголт нь нийгмийн тодорхой үе шат дамжсаар санхүүгийн тайланг илэрхийлэгч үндсэн байгууллага, түүний хэрэглэгч болох хөрөнгө оруулагчид, зээлдэгч, бэлтгэн нийлүүлэгч нарын ашиг сонирхлын ялгаа, мэдээлэл алдаатай илэрхийлэгдэх, мэдээллийн хязгаарлагдмал байдал, мэдээллийн нарийн төвөгтэй байдал зэргээс хамаарч тухайн мэдээлэл үнэн зөв болохыг батлах хөндлөнгийн хяналтын үйл ажиллагаа гэдгээр ойлгогдох болжээ.

Аудитын тухай ойлголт

Аудит гэдэг нь эдийн засгийн үзэгдэл юмсын батламж мэдэгдлийг зохих шалгуурын дагуу үнэн зөв эсэхийг холбогдох нотолгоог нь цуглуулах замаар дүгнэлт санал гаргаж, үр дүнг хэрэглэгчдэд хүргэх үйл явц юм.

Аудитын тухай ойлголт

Аудитыг явуулснаар мэдээллийн үнэн зөв, найдвартай байдал дээшилж, хэрэглэгчийн мэдээллийн эрсдэл багасдаг. Мэдээллийн эрсдэл гэдэг нь мэдээлэл буруу байснаас хэрэглэгчдэд учрах хохирол юм.

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд аливаа бизнесийн амжилтын үндэс нь үнэн бодитой, үнэ цэнэтэй мэдээлэл болсон. Хаана хөрөнгө оруулалт хийвэл ашигтайг мэдэхийн тулд хөрөнгө оруулагчид, зээл өгвөл найдвартай эсэхийг мэдэхийн тулд банкныхан, хөрөнгийн ашиглалт хадгалалтад хяналт тавихын тулд эзэд, бизнесээ амжилттай явуулахын тулд менежерүүдэд бодит мэдээлэл хэрэгцээтэй байдаг. Санхүүгийн ба санхүүгийн бус үнэн зөв мэдээллийн ачаар хязгаарлагдмал нөөц шаардлагатай салбар руу урсаж байдаг.

Аудитын тухай ойлголт

“Аудит гэдэг нь аудитор, аудитын байгууллагаас хууль, гэрээний дагуу хуулийн этгээд, хувиараа аж ахуй эрхэлж байгаа иргэний санхүүгийн баримтыг шалгах, магадлан шинжилгээ хийж дүгнэлт гаргах санхүүгийн асуудлыг судалж, төлөвлөх талаар үйлчлүүлэгчдэд зөвлөх туслах хараат бус үйл ажиллагаа” гэж тодорхойлсон.

Аудитыг санхүүгийн хяналт шалгалттай хутгаж ойлгох явдал байдаг. Аудит нь санхүүгийн хяналт шалгалтаас ихээхэн өргөн хүрээтэй ойлголт юм. Аудит зөвхөн мэдээлэл үнэн зөв эсэхийг магадлаад зогсохгүй бизнесийн үйл ажиллагааг үр ашигтай эрхлэхэд нь бизнес эрхлэгчдэд туслах зорилготой.

Аудитын тухай ойлголт

№	Үзүүлэлт	Санхүүгийн хяналт шалгалт	Аудит
1	Зорилго	Санхүүгийн сахилга бат, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих	Мэдээллийн үнэн зөв эсэхийн батлах
2	Гүйцэтгэх хэлбэр	Төр, Засгийн газрын байгууллагаас үүрэг авч хэрэгжүүлнэ	Бизнесийн үйлчилгээ үзүүлж буй хэрэг юм
3	Шийдвэр гаргах байдал	Зөрчлийн талаар акт бичиж, хариуцлага хүлээлгэнэ	Аудиторын дүгнэлт, тайлан, зөвлөмж бичнэ
4	Өмчлөл	Төрийн	Хувийн
5	Баримтлах хуулийн акт, мэргэжлийн стандарт	Төрийн хууль, дүрэм, журам	НББ-ийн стандарт, аудитын стандарт, НББ-ийн талаар мөрдөж буй хууль, дүрэм, журам, бусад

Аудитын тухай ойлголт

Аудитор нь НББ-ийн талаар өргөн мэдлэгтэй хүн байхаас гадна аудитын арга горимыг эзэмшсэн, ёс суртахууны хувьд зөв төлөвшсөн хүн байх ёстой.

Аудитын тухай ойлголт

Аудитын дөрвөн онол (*Hayes et al. (2005)*)

Цагдаагийн онол (*policeman theory*)

Аудиторын ажил бол залиланг илрүүлэх ба түүнээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн мэдээллийн арифметик тоцооллыг нягтлах юм.

Найдаж болох онол (*Lending Credibility theory*)

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан нь хувьцаа эзэмшигчдийн зүгээс менежерүүдийн удирдлага зөв гэдэгт найдах итгэлийг бэхжүүлдэг.

Аудитын тухай ойлголт

Аудитын дөрвөн онол (*Hayes et al. (2005)*)

Итгэлтэй байх онол (*Theory Inspired Confidence*)

Аудитын үйлчилгээний хэрэгцээ нь гадны хувьцаа эзэмшигчдийн оролцоо байгаагийн үр дагавар юм. Хувьцаа эзэмшигч өөрийн оруулсан хувь нэмрийнхээ төлөө хариуд нь компаний удирдлагаас хариуцлагатай байхыг шаардана. Менежерүүдийн өгч буй мэдээлэл бодит байдлаас гажсан байж магадгүй гэж үзэх тул тэд санхүүгийн тайланд аудит хийлгэж мэдээлэхийг шаарддаг.

Агентын онол (*Agency Theory*)

Компани гэдэг бол түүнд хувь нэмрээ ямар нэг хэлбэрээр оруулж буй хэсэг бүлгүүдийн албан ёсны гэрээ, хэлэлцээрийг холбогч сүлжээ юм. Нэр хүнд бүхий аудитортой хийх хэлэлцээр, гэрээт ажлын хэрэгцээ зөвхөн гуравдагч талын бус компаний менежерт бас бий.



АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТА
БҮХЭНД БАЯРЛАЛАА.